

Хожимдоогүй илрүүлэг

Хавдар судлалын үндэсний төвийн баруун жигүүрт, 4 дүгээр давхрын богинохон цагаан коридорт эмч сувилагчид зөрөх болгонд анхааралтай ажиглаж, хэн нэгнийг хүлээж буй нь ойлгомжтой хэсэг хүний дунд хоёр сар тутмын үзлэг, хяналтдаа орохоор ирсэн Г.Цэндсүрэн гуй бэрийнхээ хамт зогсож байсныг бид хожуу таньсан.

Монгол Улсад элэг, ходоод, уушги, улаан хоолой, умайн хүзүүний хорт хавдар зонхилон тохиолддог ба элэгний хавдрын эзлэх хувь дэлхийн дунджаас хэд дахин өндөр, 185 орноос нэгдүгээрт жагсаж байгаа. 2021 оны статистикаар манай улсад хавдраар оношлогдон, эмчилгээ хийлгэж буй 24141 хүн амьдардаг ба тэдний 75 хувь нь өвчнийхөө хожуу шатанд оношлогдож буй дүн шинжилгээ байдаг.

Хэнээс хэрхэн мэдээлэл авах ямар ч төсөөлөлгүйгээр Хавдар судлалын үндэсний төвийг зорьсноор Ерөнхий мэс заслын тасгийн хоол боловсруулах замын мэс заслын эмч М.Чинзоригтой уулзахаар товлосон юм. ХСҮТ-ийн төв хаалгаар ороход хөл хөдөлгөөн их, цахим бүртгэлийн цонхнуудад очерлосон хүмүүсийн цуваа урт. Болзсон цагаасаа 3 цагийн өмнө ирээд эмчийг хүлээх зүүр Г.Цэндсүрэн нүдэнд их туссан боловч очоод ярилцах зориг гарсангүй төдийгүй нэг хүнтэй уулзахаар зэрэгцэн зогсоогоо яахин мэдэх билээ.



“ХСҮТ”. 2023.12.07. УБ хот, БЗД. Гэрэл зургийг Э.Долгөөнтамир

Чинзориг эмчийн хяналтад байдаг Г.Цэндсүрэн нь Увс аймгийн Наранбулаг сумын харьяа, 61 настай. Жилийн өмнө энэ үеэр бага хүүгийнхээ хүүхдийг хараад сумандаа байх хугацаандаа эрт илрүүлэгт хамрагдаж, улаан хоолойноо “асуудалтай” гэснээр ходоодны хорт хавдартай хэмээн оношлогдож, аймагтаа очиж үзүүлэхдээ элэгний хортой хавдартай талаараа олж мэджээ. Ийнхүү Улаанбаатарт ХСҮТ-д ирснээр энэ оны 1 дүгээр сард, нэг өдөрт хоёр хагалгаанд орсон байна. Мэс ажилбар түс бүр 5 цаг үргэлжилсэн төдийгүй анх 93 кг жинтэй байсан ч хатуу хоолны дэглэм, хүндхэн хагалгаануудын дараа одоо 44 кг болтлоо түржээ.



“Т.Цэндсүрэн ярьж буй нь”.2023.12.07. Улаанбаатар хот. Гэрэл зургийг Э.Дөлгөөнтамир

Анх хорт хавдартайгаа мэдсэн үеийн сэтгэгдэл мэдрэмж, давж гарах хүртэлх сэтгэл зүй нь ямар байсныг онцлон асуухад “Эрт илрүүлгийн ачинд л эрт мэдэж чадсан, тийм ч болохоороо эмчлэгдсэн гэж боддог. Хэдий эхэндээ хэцүү санагдаж, үйлж хямарсан ч гэлээ хавдраа аваад хаячихвал эдгэнэ гэж бодсон, гэхдээ бас зүрх дийлэх нь үү гэж айсан шүү. Эмч нар намайг их дэмжсэн, тэгээд итгэсэн дээ. Одоо эмчийн байнгын хяналтад байдаг, энэ хүнийг эрүүл саруул болгочих юмсан гэсэн сэтгэлтэй хүүхдүүд шиг санагддаг. Эрт өөртөө анхаараад эдгэрсэн болохоор бусад хүмүүстэй харьцуулахад гайгүй ээ” хэмээн хариулсан юм.

Яагаад, юунаас шалтгаалж хавдартай болсон бэ гэдэг асуултад тогтсон нэг хариулт гаргаж ирэх хэцүү, хавдар үүсгэдэг багадаа 2-3 хүчин зүйл нэгдэж байж л ийм зүйл болно уу гэхээс зүгээр нэг өдөр үүсчихдэг юм биш ажээ. Магадгүй удамшлын өвчин, хаанаас халдсан нь үл мэдэгдэх В, С вирус, буруу хооллолт, нойр булчирхай, сахарын илүүдэл, цөсний үсэрхийлэл ч байж болох.

Хоол боловсруулах замын мэс заслын эмч М.Чинзориг: “Хорт хавдар нэг л өдөр бий болдоггүй, дор хаяж 10 жилийн хугацаанд бий болно. Г.Цэндсүрэн өвчтөний хувьд элэг нь В, С-тэй байсан, учир нь залуудаа цусны донор болж байхдаа тарианы зүүнээс халдвар авсан байж болзошгүй, мөн хавдартай гэж оношлогдохоосоо өмнө цөс нь чулуужсан болохоор тайруулж байсан. Түүнээсээ үсэрхийлж ходоод нь өвчилсөн. Үүнээс гадна удамшлын өвчин байсныг үгүйсгэхгүй, баруун аймгуудын хувьд ундны ус нь давслаг ихтэй мөн газрын хатуулаг дээр амьдардаг учраас ер нь л эрсдэл ихтэй гэсэн үг” гэж тайлбарлалаа.

Осол гэмтлээс бүрэн сэргийлэх боломжгүй ч хорт хавдрыг эрт илрүүлэх боломжтой. БНСУ өнөөдрийг хүртэл ходоодны хорт хавдрын өвчлөлөөр тэргүүлсээр байгаа ба тэдэнд одоогийн бидэн шиг нас баралтаараа дээгүүр бичигдэж явсан үе бий боловч 1990 оноос эрт илрүүлгийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ.

Насны стандартчилсан түвшингээр 100'000 хүн тутамд ходоодны хорт хавдрын өвчлөлөөр Солонгос 41.8%, Монгол 32.5% байдаг бол нас баралтаар манай улс 12.3%-иар илүү үзүүлэлттэй байдаг. ХСҮТ-ийн ерөнхий захирал Н.Эрдэнэхүү “Өмнө нь хавдрын өвчлөл 6,500 орчим байсан бол 2022 онд шинэ тохиолдол 6,882 гэж гарсан. Шинэ тохиолдол бүрийг бүртгэх гэж хичээж байна. Дараа жил гэхэд 7,000 гарах зураглалтай байгаа. Гэхдээ хожуу шатанд илэрч байгаа өвчлөл буурахгүй байгаа учраас эрт илрүүлэх үйл ажиллагаа ч цаашид илүү тогтворжсон байдалтай явагдах ёстой” гэж энэ оны 8 дугаар сард ikon.mn сайтад өгсөн ярилцлагадаа дурджээ. Өөрөөр хэлбэл хавдрын өвчлөл ихсэж байгаа ч нас баралт 2021 онтой харьцуулахад 200-гаар багассан байна. Энэ бол эрт илрүүлгийн ач гавьяа гэхэд хилсдэхгүй биз ээ.



Г.Цэндсүрэн гуайг өдрийн турш хөтлөн явж, үзлэг бүхэнд хамт орж буй залуухан бүсгүй бол түүний бага бэр С.Гэрэлжаргал. Ээж маань гээд дотночлох тэрбээр 6 сар тутам шинжилгээнд хамрагдах нь ямар ач тустай болон өөрөөс нь гадна нөхрийн нь ах дүү нар ээлжлэн асарч тойглодог болохыг хуваалцсан юм. Бараг арваад сарын өмнө мэс заслын эмчилгээ дууссан ч түүртэж, төвөгшөөсөн шинжгүй хадам ээжийгээ дагуулан явна.



“ХСҮТ, 4-р давхар”. 2023.12.07. Улаанбаатар хот. Тэрэл зургийг Э.Дөлгөөнтамир

“Хоёр сардаа нэг удаа ирж хянуулдаг, үс гэж хэдэн сөөсгөр юм л үлдлээ, гамаа сайн барьвал ахиад эмээд нь арван жил байгаа гэж эмч нар хэлсэн. Удахгүй сумынхаа ойн баярт очно, тэр хүртэл жин ч нэмэх хэрэгтэй” гэж тун өөдрөг хэлэв.

ХСҮТ-д хорт хавдар гэж оношлогдсон хүн хандахад эмчилгээг эрүүл мэндийн даатгалаас бүрэн хариуцдаг юм байна. Г.Цэндсүрэнгийн элэг тайрах, ходоодны мэс засал нийлээд ойролцоогоор 10 сая төгрөг болсон ч ЭМД-ын ачаар үнэгүй хагалгаанд орсон гэнэ. Гэвч эм тарианд хувиасаа 15 сая орчим төгрөг зарцуулжээ. Сард таван удаагийн гурван курс тариа гэхэд л 2’500’000 төгрөг болсон байна.

Бид Г.Цэндсүрэн болон түүний бэрийг үдсэний дараагаар М.Чинзориг эмчтэй дэлгэрэнгүй ярилцсан ба “Нэг дор хоёр хавдраар оношлогдох ийм тохиолдол ховор биш буюу ХСҮТ-д нэг жилд ойролцоогоор 3-4 илэрнэ. Монголд бид хойноос нь л явдаг. Азаар гайгүй эрт илрээд бүрэн эдгэрсэн нь ч байна, гэвч хамгийн сүүлийн шатандаа орчхоод ядаж л эрт илрүүлгээр мэдэж авлаа гээд харуусаад ярих нь илүү олон. Тэр тусмаа орон нутагт оршин суудаг иргэд бол мэдлээ ч, ойр тойрондоо төвөг учруулахгүй гээд хаячихдаг хандлагатай.”



“М.Чинзориг эмч”. Гэрэл зургийг Gogo.mn

Бидний мэдэхгүй хэчнээн илрүүлээгүй хавдрын хор хохирлыг амсаж, тэнгэрт заларч буй хүмүүс байгааг таашгүй. Монголчууд ямар эрүүл мэндээ хайхардаггүй, өөрсдийгөө, нэгнийгээ хайрладаггүй, амьдралын буруу хэв маягтай гэдгийг өдөр тутамдаа эргэн тойрноосоо харж болох мэт. Эрт илрүүлэг хөтөлбөр сүүлийн 3 жилийн турш идэвхтэй явагдаж, улсынхаа иргэн бүрийг жигд хамруулах үүднээс сурталчлах, таниулах ажлууд ихээр хийгдэж байгаа. Гэхдээ хэр үр нөлөөгөө өгч байгаа нь эргэлзээтэй. Иргэдийг өвчлөлтэй эсэхийг тогтоох нь энэ үйл ажиллагааны хамгийн гол зорилго байх учиртай. Магад цаашдаа бусад улс орноос тун ч их “хоцорч” яваа эрүүл мэндийн салбар маань үрт хугацааны эрүүл иргэн байх боломжоор ард түмнээ хангадаг болох, хожимддог тоогоо эртэлдэг тоо нь дийлэх сайхан цаг ирнэ гэдэгт итгэнэ.

МУИС-СЗОНХТ 3-р түвшний оюутан

Э.Дөлгөөнтамир

2023 онд бичив.